

## БНХАУ-Д КУЛЬТИЙГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ТҮРШЛАГААС

*О.Бумдарь (Докторант)  
ӨМИС-ийн Монгол судлалын сургуулийн  
Монгол түүхийн ухааны салбар*

**Түлхүүр үгс:** *хятад улс; культ; хуулийн зохицуулалт; нууц бүлгэм; мухар сүсэг*

**Товч утга:** *Тус өгүүлэлд БНХАУ-д культийг авч үзэх ямар үзэл, хандлага давамгайлж байгаа талаар өгүүлж, мөн Хятадын төрөөс культийн тухайд баримталж буй бодлого, зохицуулалтын тухай товчхон хөндөв.*

\* \* \* \* \*

Өнөөдөр Хятад улс нь шашны оновчтой бодлого хэрэгжүүлснээр нийгэмд олон шашин, олон шашны бүлгэмүүд, шашныг шүтдэг болон эс шүтдэг иргэд хоорондоо харилцан биенээ хүндэтгэсэн, эв найртайгаар, зэрэгцэн хамт оршиж байна гэж үзнэ.<sup>1</sup> Хятад улс нь Үндсэн хуулиндаа шашин шүтэх эрх чөлөөг баталгаажуулж, Үндсэн хуулийн 36 дугаар заалтад: “Манай улс нь хэвийн шашны үйл ажиллагааг хамгаална”<sup>2</sup> гэсэн буй. Хэдийгээр Үндсэн хууль болон бусад хуулиндаа “хэвийн” шашин гэж чухам ямар шашныг авч үзэх нь тодорхойгүй боловч Үндсэн хуулийн дээрх заалтыг тайлбарлахдаа: “Шашны үйл ажиллагаа нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журмын дагуу, төрийн бодлогын хүрээнд явагдах ёстой”<sup>3</sup> гэжээ. Үүнийг хуульчид болон шашин судлаачдаас хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй, хууль ёсны шашныг “хэвийн” шашин гэж тайлбарлаж байна. Энэ утгаараа хятадад төрийн зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн бурхны шашин, даогийн шашин (Daoism), исламын шашин, католик шашин, протестант (Christianity) шашин, үндсэндээ энэ “таван шашин” хийгээд тус шашнуудын үндэсний шинж чанартай 8 холбоо<sup>4</sup> нь хятад улсын хуулиар хамгаалагдсан “хэвийн шашин” мөн хэмээн үзэж буй. Харин сургаал номлол нь бүрэн тогтоогүй, гэгээрүүлэх чанаргүй, сахил санваар, дүрэм журамгүй шашин шүтлэг нь “хууль ёсны” шашны ай (ангилал)-д харьяалагдахгүй гэжээ.<sup>5</sup>

Тэгвэл энэхүү “хэвийн шашин” гэсэн ангилалд “үл багтах” хэсэг нь “xie jiao” буюу англи хэлний орчуулгадаа “Cult”<sup>6</sup> гэсэн ухагдахуунаар ойлгогдож хятадын нийгэмд нэгэнт

<sup>1</sup> 陆中俊主编：《我国对当代邪教组织犯罪问题的对策与治理》，北京：中国人民公安大学出版社，2005年，第184页。

<sup>2</sup> 《中华人民共和国宪法》，北京：中国民主法制出版社，2018年，第83页。

<sup>3</sup> 内蒙古自治区教育厅学校安全管理处：《学校防范邪教》，呼和浩特市苏虎街实验小学印刷厂，2016年，第5页。

<sup>4</sup> Хятадад өнөөдөр Хятадын Бурхны шашны холбоо, Хятадын Даогийн шашны холбоо, Хятадын Ислам шашны холбоо, Хятадын Католик шашны холбоо, Хятадын Католик шашны боловсролын удирдлагын хороо, Хятад дахь Католик шашны хамба лам нарын хурал, Хятад дахь Протестант сүм хийдүүдийн гурван эх оронч хөдөлгөөний үндэсний хороо гэсэн 8 үндэсний шинж чанартай “бүлгэм” ажиллаж байна. 2005 оны байдлаар мужийн дэсийн 164 шашны бүлгэм, шяний дэсийн 2000 бүлгэм мөн Хятадын бурхны шашны академи, Хятадын исламын шашны институт, Хятадын христийн шашны Нанжины нэгдсэн теологийн сургууль, Хятадын католик шашны теологийн сургууль, Хятад дахь библийн сургууль зэрэг 47 шашны сургууль ажиллаж байжээ. Тус улсад тогтмол хэвлэлийн шашны 10 гаруй төрлийн сэтгүүл гардаг, мөн улсын хэмжээнд 200 мянга орчим мэргэжлийн шашны ажилтан ажиллаж, түүний дотор 9000 орчим хүн нь муж, хот, өөртөө засах зэрэг олон дэсийн ардын төлөөлөгч, Хятадын улс төрийн зөвлөгөөний гишүүдээр сонгогдон ажиллаж байжээ.

<sup>5</sup> 冯玉军：《邪教的法律性质及其治理创新》，北京：北京联合大学学报(人文社会科学版)，2014年第46期，第57页。

<sup>6</sup> Хятадаар “邪教”(xie jiao) гэсэн үгийг англи хэлний “cult” гэсэн үгээр дүйцүүлсэн байх бөгөөд энэ ухагдахуунд “тэрс,

хэвшжээ. Гэхдээ тус “xie jiao”(культ) ангилалд ардын дундах “нууц бүлгэм”(Hui Dao Men)<sup>7</sup>, “хийн тамирын бясалгал”, “тэрс номлол”, “мэргэ төлгө-мухар сүсэг”, шашны нэр барьсан мөнгө хүүлэл зэргийг багтаасан нь ажиглагдана.

Шашны бодлого бол хятадын онцлогтой социализмын шинэ үеийн хөгжилд холбогдох нам, төрийн бодлогын чухал хэсэг гэж үзнэ. Харин культгийн асуудал нь олон улсад хятад дахь хүний эрх, шашны эрх чөлөөг хөндсөн нэгэн ярвигтай асуудал хэвээр байна. Иймээс хятадын олонхи судлаачид культ бол шашин биш гэж үзэх бөгөөд хятадын дотоодод энэ үзэл, суртал хүчтэй явагдана. Учир нь аливаа культийг шашин гэж үзсэн тохиолдолд шашны эрх чөлөөг хангах, шашны тухай төрийн бодлогод зөвшөөрөгдөх зэрэг бүх талын хамгаалалтад орж энэ нь даруй төрөөс культийн эсрэг урьдчилан сэргийлэх ажиллагааг явуулахад тун хүнд болно хэмээн тус орны олон судлаачид үзэж байна. Иймээс культгийн талаарх судалгааг эрчимжүүлж, культийн шашны бус шинж чанарыг онол-практикийн хувьд үндэслэхийг оролджээ. Энэ тухайд, культ нь өөрөө хүний эрх, шашны эрх чөлөөнд халдаж байна гэж үзнэ. Иймд культийг хориглох нь хүний эрх, шашны эрхийг зөрчих бус харин ч “культийг эсэргүүцэж, хүний эрхийг хамгаалья”, “культэд цохилт өгч, шашныг хамгаалья”, “культийг эсэргүүцье, шашны эрх чөлөөг хангая”, “шинжлэх ухааныг эрхэмлэж, культийг хориглоо” зэрэг лоозонг дэвшүүлж байна. Энэ утгаараа юуг шашин гэж үзэх вэ, юуг культ гэж үзэх вэ, шашин болон культийн ялгаа нь юу болох, культийн шинж чанар, онцлог, хор хөнөөл зэргийг тодорхойлж энэ тухай иргэдэд идэвхитэй сурталчилж, культээс хэрхэн сэрэмжлэх, хэрхэн татгалзах талаар хөдөө тосгодоос аваад улсын хэмжээнд олон ажлыг өрнүүлж байна. Улсын үндэсний аюулгүй байдал, ард түмний эв нэгдлийг сахин хамгаалах нь төрийн үндсэн үүрэг, харин культийн эсрэг үйл ажиллагаа нь түүний нэг хэрэгжилт мөн гэж тайлбарлаж байна.

Хятадын шашин судлаачид “шашны утга агуулгатай боловч бодит байдал дээр засгийн газрын эсрэг, шинжлэх ухаан, нийгэм, хүн төрөлхтний эсрэг шинж чанартай шашин, эсвэл өөрийгөө шашин гэж нэрийдэж буй аливаа зохион байгуулалт нь культэд харъяалагдана”<sup>8</sup> хэмээн тодорхойлжээ. Судлаачдаас культийн тухай өгсөн олон онцлог шинж, тодорхойлолтод<sup>9</sup> культэд “засгийн газар, хуулийн эсрэг” шинж агуулагддаг гэдгийг хятадын олон судлаачид хүлээн зөвшөөрч, энэ тухай онцлон дурджээ. Тухайлбал, культийн тэргүүн, багш нар нь өнөөгийн Хятад улсын шашнаас ангид (secular state) төрийн эрхийг түлхэн унагааж, теократ төрийн ноёрхлыг тогтоохыг санаархдаг.<sup>10</sup> Тэд шашин, амьсгалын - хийн тамирын дасгал эсвэл бусад нэрийг ашиглан төрийн эрхийг эсэргүүцэх үйл ажиллагааг явуулсаар ирсэн. Учир нь одоогийн буруу номлол нь угийн тэрслүү нууц бүлгэмийн өвийг залгамжлан

*гаж, буруу, харгис номлол, тэрс шашин” гэсэн утга бүгдийг багтаасан байна.*

<sup>7</sup> Энэ нь тодорхой нэг шашин, эсвэл шашны урсгалыг тусгайлан заасан нэрийдэл бус, харин Хятадын нийгэмд нэн эрт үеэс оршиж ирсэн, шашин хийгээд мухар сүсгийн шинж чанартай нийгэм дэх хууль бус зохион байгуулалт, ардын дундах нууц эвлэл, бүлгэмүүдийг заасан ерөнхий нэрийдэл ажээ. Хуулиндаа бол Хуй Дао Мен хэмээн бичиж, Шинэ Жао(культ) гэдгээс бага ялгаатай утгаар авч үзэж буй ч, шашин судлалын үүднээс бол культ гэсэн ангилал, ухагдахууны хүрээнд авч үзжээ.

<sup>8</sup> 刘正峰, 周新国: 《邪教的法律治理》, 北京: 社会科学文献出版社, 2012年, 第1页.

<sup>9</sup> 蔡少卿, 孔祥涛: 《试论当代邪教的九个特点》, 江苏: 江苏社会科学, 1997年第6期; 李昭主编: 《邪教·会道门·黑社会 - 中外民间秘密结社纵横谈》, 群众出版社2000年版, 第5-7页 - ээс үзнэ үү.

<sup>10</sup> Фа Лун Гүн буюу хийн тамирын шинж чанартай нэг төрлийн культ нь Хятадын Жи Линь мужийн Чань чун хотын ажилчдынхаа цалинг тавьж чадахаа болсон үр тариа, тос, хүнсний бүтээгдэхүүний нэгэн компаний цалингүй ажилчин Ли Хун Жи гэгч хүн 1992 онд анх үүсгэн байгуулжээ. Ли Хун Жи нь өөрийгөө тахин шүтүүлж, үйл ажиллагаагаа хятадын 20 гаруй мужид тэлэн өргөжүүлж, 2 сая гаруй хүнийг татаж, хятадын хамгийн том хийн тамирын бүлгэм болсон байна. 1994 оны 4 сард итгэн дагаасад 10 мянган хүнийг зохион байгуулж Хятадын нам төрийн төв байрыг бүслэн, олон цаг үргэлжилсэн жагсаал, цуглаан явуулжээ. Ингэхдээ “коммунист намын тухай есөн шүүмж”-ийг гаргаж, Хятадын коммунист намын төрийг удирдах байр суурийг бүхэлд нь үгүйсгэж, нийгэм журамт байгуулалт нь харгис хэрцгий улс төрийн мөн чанартай болох тухай ил тод шүүмжилж байжээ. 2000 оны байдлаар Фа Лун Гүн бясалгалаас үүдэн 1500 хүн нас барж, 20 гаруй хүн алагдаж, 600 гаруй хүн сэтгэл мэдрэлийн өвчтэй болж, хөдөлмөрийн чадвараа алдсан байна. Фа Лун Гүн-ийг 1999 оны 7 сард хориглосон бөгөөд мөн сардаа эв хамт намын төв хорооноос “эв хамт намын гишүүн Фа Лун бясалгалд суралцахыг хориглоно” гэж тогтоожээ. - 颜邦华: 《宗教法立法诺干问题的探讨》, 湖北: 《湖北社会科学》2001年第1期第15页. <http://xwjz.eastday.com/epublish/epublish/140/18/class014000004/hwz297143.htm>

үргэлжлүүлэгчид юм гэжээ.<sup>11</sup>

Хятадад культийн судалгааг нэн эртнээс буюу нийтийн он тооллын өмнөх үеэс эхлүүлэн өгүүлэх агаад Чингийн сүүл үе, хар тамхины дайны дараа ихэд идэвхижиж ирсэн гэжээ.<sup>12</sup> Энэ үед ардын дунд нууц эвлэлүүд байгуулагдан шинжлэх ухаан, ардчиллыг эсэргүүцэхээр эхэлж даруй “нууц бүлгэмүүд”-д улиран шилжжээ. Эдгээр бүлгэмүүд нь японы империализмыг эсэргүүцэх үед нилээд задралд орж, харин соёлын хувьсгалын үед төрөөс үндсэндээ дарсан гэж үздэг байна. Гэвч Хятад улс 1978 оноос “өөрчлөлт, нээлттэй” болсны дараа нийгэмд нууц бүлгэм, культууд шинээр буй болж, нийгэм дэх хор хөнөөл нь явах тутам улам ноцтой болж иржээ. Улмаар 1979 оноос Хятадын засгийн газраас культуудийн хууль зөрчсөн үйлдэлд шийтгэл өгч, нийгэмд цар хүрээгээ тэлэхийг нь хориглосон хууль, эрх зүйн шат дараалсан олон арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

1982 онд Хятадын Коммунист намын төв хорооноос гаргасан тогтоолын 19 дүгээр баримтад “нэгэнт хориглогдсон нууц бүлгэм болон гадаадын шашны зохион байгуулалтыг дотоодын шашны зах зээлд үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Хэрвээ зөрчвөл шууд хориглож, улсаас албадан гаргана... нэгэнт хориглогдсон аливаа тэрс шашин, бөө удган, илбэчин, домч нарыг үйл ажиллагаагаа дахин явуулахыг үл зөвшөөрнө. Олон түмнийг хуурч мэхлэхийг хатуу хориглож, шударга ёсыг тогтооно”<sup>13</sup> гэж заажээ. Улмаар 1983 оноос эхлүүлэн Дотоодыг хамгаалах яам(Ministry of Public Security)-аас хэд хэдэн удаагийн нэгдсэн хяналт шалгалт явуулж, 1983-оноос 1991 оны хооронд улсын 20 муж, өөртөө засах орны нийт 360 шяний 200 мянга гаруй хүнийг элсүүлээд байсан “хашхирааны бүлэг”<sup>14</sup>, улсын 15 мужийн 120 газар (хот)-ын 681 шяний 350 мянган хүнийг элсүүлсэн “дагалдагчийн нийгэмлэг”<sup>15</sup> зэрэг 4 том культийг “нийгмийн хэв журмыг алдагдуулсан” гэсэн үндэслэлээр хориглосон байна. Гэвч 1990 он гэхэд төрөөс шашны асуудлыг шийдвэрлэж буй эрх зүйн зохицуулалт нь тухайн үеийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй хэмжээнд хүрчээ. Иймээс 1991 онд Хятадын Коммунист намын төв хороо болон Төрийн зөвлөлөөс “шашны ажлыг илүү сайжруулах зарим асуудлын тухай мэдэгдэл” хийж, үүнд төрөөс шашны тухай баримтлах бодлого, зохицуулалтыг сайжруулах, шашны эрх зүйн орчныг боловсронгуй болгох тухай үндсэн асуудлыг тусгажээ. Улмаар эн түрүүнд Улсын шашны хэрэг эрхлэх газраас 1989 онд Төрийн зөвлөлөөс гаргасан “нийгмийн бүлгүүдийн бүртгэл удирдлагын тухай дүрэм”-д үндэслэн “шашны байгууллагуудын бүртгэл, хяналт удирдлагыг хэрэгжүүлэх зарчим”-ыг 1991 онд батлан гаргав. Мөн 1991 оны 2 сард Намын төв хороо, Төрийн зөвлөлөөс “6 дугаар баримт бичиг”-ийг нийтлэж, үүнд “гадны ямарч шашны байгууллага болон хувь хүнийг манай улсын шашны хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглоно, мөн хятадад албан газар, сүм хийд байгуулах, шашин дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулахыг үл зөвшөөрнө... манай улсад хууль бус этгээдүүд хууль бус зохион байгуулалт байгуулах, шашны хууль бус судар бичгийн сургууль, семинар, шашны хүрээлэн нээн ажиллуулах зэрэг... хууль бус шашны зохион байгуулалтыг шууд хориглоно”<sup>16</sup> гэжээ. Өмнө нь гадаадын шашны байгууллага хятадад нэвтрэхэд бүртгэлгүй бол үйл ажиллагаа явуулахыг хориглож байсан бол уг заалтаар байгууллага төдийгүй гадаад, дотоодын иргэдэд ч нэгэн адил үйлчлэхээр заажээ.

Үргэлжлүүлэн Хятадын засгийн газраас “Шашны үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын дүрэм” (1994 он), “БНХАУ дахь гадаадын иргэний шашны үйл ажиллагааг хянан, зохицуулах тогтоол”, “Шашны хэрэг эрхлэх дүрэм” (2004 он) зэрэг хууль, эрх зүйн баримт бичгүүдийг батлан гаргаж мөрдүүлжээ. Энэ нь нэг талаар төрөөс шашны тухай

<sup>11</sup> 陈运雄:《中美治理邪教的法律与政策比较》,湖南:湖南农业大学出版社,2016年第12期,第42页。

<sup>12</sup> 陈运雄:《中美治理邪教的法律与政策比较》,湖南:湖南农业大学出版社,2016年第12期,第42页。

<sup>13</sup> 刘正峰,周新国:《邪教的法律治理》,北京:社会科学文献出版社,2012年,第203页。

<sup>14</sup> 刘正峰,周新国:《邪教的法律治理》,北京:社会科学文献出版社,2012年,第230页。

<sup>15</sup> 刁五一:《当代中国邪教性质及其社会根源—兼论建立“邪教现象预警系统”》,社会问题研究丛书编辑委员会编《论邪教》,南宁:广西人民出版社,2001年。

<sup>16</sup> 刘正峰,周新国:《邪教的法律治理》,北京:社会科学文献出版社,2012年,第205页。



баримтлах бодлогын эрх зүйн орчныг боловсронгуй болгосон бол нөгөө талаар культийг хуулиар хянах, культтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж өгчээ. Өөрөөр хэлбэл төрөөс шашны эрх чөлөө, шашны эрх тэгш байдлыг хангаж, хэвийн шашныг хамгаалж, харин нууц бүлгэм, шашнаас үүдэлтэй хууль бус асуудлыг цэгцлэхэд томоохон алхам болжээ.

Энэ үндсэн дээр 1995 онд БНХАУ-ын Коммунист намын төв хорооны төв танхим, Төрийн зөвлөлийн төв танхимаас “Дотоодыг хамгаалах яамнаас “Хашхирааны” бүлэг зэрэг культийн зохион байгуулалтыг хянан шалгасан байдлын тухай ба ажлын санал” гэсэн мэдэгдэл (50 дугаар) хийж, түүнд “эв нэгдлийн сүм” зэрэг хориглогдсон 7 төрлийн культийн жагсаалтыг гаргажээ. Үүний дараа 2000 онд Хятадын Дотоодыг хамгаалах яамнаас “культийг илрүүлэн тогтоож, хориглосон хэдэн асуудлын тухай мэдэгдэл” (39 дүгээр)<sup>17</sup> хийж, түүнд 1995 оноос 1999 оны хооронд хориглогдсон 8 культийн нэрийг зарласан байна. 2005 онд Дотоодыг хамгаалах яамнаас өмнө нь нэгэнт тогтоогдож, хориглогдсон 14 культийн<sup>18</sup> нэрийн жагсаалтыг гаргажээ. Энэ 14 культийг Засгийн газраас нэн “аюултай” хэмээн тооцож, тэдгээрийн үүсэл гарал, тархац, номлол сургаалийн онцлог, зорилго, шинж чанарыг тодорхойлж адил төстэй шинжээр нь 4 бүлэгт хуваан авч үзсэн байдаг. Мөн “БНХАУ-ын культийг эсэргүүцэх нийгэмлэг”-ээс 2014 онд 11 культийг бүртгэсэн жагсаалт гаргаж, нийгэмд сэрэмжлүүлэг болгожээ. Үүнд дээрх 14 дотор нэр нь ороогүй хориглогдсон 4 культийн<sup>19</sup> нэр орсон байна. Ийнхүү Хятадад үйл ажиллагаа явуулж, эдүгээ хориглогдсон культийн тоо (жагсаалт) 22-д хүрчээ. Эдгээр культуудийг гарал үүслээр нь дотоод, гадаад гэж ангилвал Гонконг, Тайванаас гаралтай 4 культийг гадаадад эс тооцвол Америк, Солонгосоос гаралтай 6 культ байх ба бусад 14 культ буюу 70% нь Хятад дотроосоо үүссэн байна.

2000 оны жагсаалтад орсон тус 14 культийн үйл ажиллагааны хамрах хүрээ нь тэр үедээ улс орон даяар нийт 782 шянь (хот), Түвдээс бусад эл муж, хот, өөртөө засах орнуудад тархаж, 500 мянга<sup>20</sup> гаруй хүнд нөлөөлсөн гэсэн тооцоог гаргажээ. Гэтэл үүний урьд 1999

<sup>17</sup> 冯玉军: 《邪教的法律性质及其治理创新》, 北京: 北京联合大学学报(人文社会科学版), 2014年第46期, 第58页。

<sup>18</sup> Хятадад хориглогдсон тус 14 культийн жагсаалт: хориглогдсон оныг (хориг ...) гэж ард нь тэмдэглэв.

1. The Shouters (呼喊派): - Ли Чан Шоу гэх Хятад 1962 онд Америкт анх үүсгэсэн (хориг 1983).

2. The Disciple Society (门徒会): - нь 1984 онд Хятадын Шанши мужид үүссэн. (хориг 1990).

3. The Lingling Sect (灵灵教): - 1986 онд Хятадын Жиан Сү мужид үүссэн. (хориг 1990).

4. Anointed King (被立王): - 1990 онд Хятадын Ан Хүй-д Уян Мин гэдэг хүн үүсгэсэн. (хориг 1995).

5. Children of God (天父的儿女): - 1968 онд Америкт үүссэн. (хориг 1995).

6. Dami Missionary Society (达米宣教会): - 1988 онд Солонгост үүссэн. (хориг 1995).

7. New Testament Church (新约教会): - 1963 онд Хонконгод үүссэн. (хориг 1995).

8. Ling Xian True Buddha School (灵仙真佛宗): - Лу Шөн Яа гэгч хүн 1979 онд Тайванд үүсгэсэн. (хориг 1995).

9. Guan yin Method (观音法门): - 1988 онд Чин Хай гэгч эмэгтэй Тайванд үүсгэсэн. (хориг 1995).

10. World Elijah Gospel Mission Society (世界以利亚福音宣教会): - 1980 онд Солонгост үүсч 1993 онд Хятадад нэвтэрсэн. (хориг 1996).

11. The Unification Church (统一教): - 1954 онд Өмнөд Солонгост үүссэн. (хориг 1997).

12. Full Scope Church (全范围教会): - Шу Юун Зө гэгч хүн 1984 онд Хятадын Хөнан мужид үүсгэсэн. (хориг 1988).

13. Lord God Sect (主神教): - 1993 онд Хятадын Ху Нан мужид үүссэн. (хориг 1998).

14. Three Grades of Servants (三班仆人派): - 1988 онд Хятадын Хөнан мужид үүссэн. (хориг 2004).

Дэрээрхээс гадна дараах 2 культ хориглогдсон культийн жагсаалтад багтана. 1. Perfect and Sudden Dharma Gate (圆顿法门): - Шу Чөн Жиан гэдэг хүн 1988 онд Хятадын Хар мөрөн мужид үүсгэсэн. (хориг 1999). 2. South China Church (华南教会): Гүн Шөн Лиан гэгч хүн 1990 онд Хөбэй мужид үүсгэсэн. (хориг 2001). Мөн культууд нь салбарлан өргөжих, эсвэл ихэвчлэн хориглогдсонхоо дараа нэрээ өөрчлөн үйл ажиллагаагаа үргэлжлүүлдэг байна. Энэ тохиолдолд бүртгэлд заримдаа үндсэн нэг нэрээр, заримдаа нэр тус бүрээр орсон байна. Жишээ нь “хашхирааны бүлэг”-ээс дээр жагсаалтад орсон “Anointed King”, “Lord God Sect” хоёроос гадна жагсаалтад ороогүй “Ability owner” (能力主) болон “Chang Shou номлол” (常受教) үүссэн гэдэг. Ингэвэл хориглогдсон культийн жагсаалтад мөн 2 культ нэмэгдэнэ.

<sup>19</sup> 1. Falungong (The Wheel of Dharma - 法轮功).

2. Church of Almighty God (全能神教会) буюу өөр нэрүүд нь Eastern Lightning (东方闪电) / True God (实际神) / New Master of Power (新能力主): - Жао Вэй Шан гэдэг хүн 1989 онд Хятадын Хөнан мужид үүсгэсэн. (хориг 1995).

3. Blood Holy Sprit (血水圣灵): - Зуо Күн гэдэг хүн 1988 онд Тайванд үүсгэсэн. (хориг 1995).

4. Mainland China Administrative Deacon Station (中华大陆行政执事站): - Ван Юн Мин гэгч хүн 1994 онд Хятадын Хөнан мужид үүсгэжээ. (хориг 1995). – ишлэсэн: <http://society.people.com.cn/n/2014/0603/c1008-25098722.html>

<sup>20</sup> 牟家骥: 《我国新时期邪教问题研究》, 山东: 《山东警察学院学报》, 2006年第3期。

онд хориглогдсон “Дхармын хүрд” (fa lun gong – The Wheel of Dharma) бясалгал нь дангаараа улсын 20 гаруй мужид тархсан, 2 сая гаруй итгэгчтэй байжээ.<sup>21</sup> Эдгээр культүүдийн тус тусын түүх, хориглогдсон шалтгааныг сонирхож үзэхэд нийгмийн хэв журам, ард олны бие эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж, нийгмийг цочроосон үйлдлүүд олон удаа гаргаж байжээ гэдэг нь харагдана.

Өнөөдөр хятадын төрөөс шашныг зохицуулж байгаа тогтолцоог авч үзвэл, үндэсний хэмжээнд шашны үйл ажиллагааг удирддаг хамгийн том байгууллага нь Намын төв хорооны дэргэдэх Төрийн зөвлөл юм. Дотоодыг хамгаалах яам болон Улсын шашны хэрэг эрхлэх газар нь Төрийн зөвлөлд шууд удирдагддаг. Улсын шашны хэрэг эрхлэх газар нь доороо орон нутгийн түвшин бүрт Шашны хэрэг эрхлэх товчоотой бөгөөд шашны бүх байгууллагууд нь “нийгмийн бүлгүүдийн бүртгэл удирдлагын тухай дүрэм” болон “шашны хэрэг эрхлэх дүрэм”-ийн дагуу Улсын шашны хэрэг эрхлэх газарт бүртгэгдэх ёстой.

1999 онд Фалунгүн-ий хэргээс хойш БНХАУ-ын Дотоодыг хамгаалах яаманд “Дотоодыг хамгаалах яамны культ (xie jiao)-ийг эсэргүүцэх товчоо” ба “культээс урьдчилан сэргийлэх болон зохицуулах асуудлын удирдах группын оффис” (албан бусаар Төв хорооны 610 дугаар оффис гэж нэрлэгддэг) гэсэн шинэ бүтцийг байгуулсан байна. Энэ оффис нь Цэрэг, Дотоодыг хамгаалах яам, Улсын шашны хэрэг эрхлэх газар, Улсын бүртгэл зэрэг газруудын культ, шашнаас үүдэлтэй хэргүүдийг хариуцаж ажилладаг байна. Тус товчоо нь хот, муж, өөртөө засах орны дотоодыг хамгаалах, цэрэг, цагдаагийн газруудтай хамтарч ажилладаг. Үүнээс гадна төрийн бус ажлыг дурдвал, 2000 оны 11 сард Бээжин төвтэй, шинжлэх ухаан-технологийн, нийгмийн шинжлэх ухааны, эрүүл мэндийн, шашны, хуулийн, хэвлэл-мэдээллийн зэрэг нийгмийн олон салбарын төлөөлөл оролцон, салбар салбарын нэртэй эрдэмтэн, зүтгэлтнүүдээр удирдуулсан “Дундад улсын культуийг эсэргүүцэх нийгэмлэг” (China Anti-Cult Association) хэмээх төрийн бус маш том байгууллагыг байгуулж өнөөг хүртэл культуийн эсрэг ажлыг үндэсний хэмжээнд өрнүүлж буйг тэмдэглэх нь зүйтэй. Мөн 2017 оны 9 сараас үндэсний хэмжээний Хятадын культ (xie jiao)-ийг эсэргүүцэх вэб сайт<sup>22</sup>-ыг нээж бас “хятадын культуийг эсэргүүцэх вэй бо (wei bo)”<sup>23</sup>(хятадын facebook)-г хот, орон нутгийн бүх түвшинд нээн ажиллуулж байна.

Хятадын удирдагч Ши Жин Пин намын 18 дугаар Их хурлын өмнө шашны асуудалд нилээд анхаарч, шашны тухай хэд хэдэн удаа мэдэгдэл гаргажээ. Тэрээр нэг удаа хэлэхдээ: шашны асуудлыг шийдвэрлэх үндсэн зарчим бол хууль ёсныхыг хамгаалах, хууль бусыг хориглох, хэт үзлийг зогсоож, нэвтрэлтийг<sup>24</sup> эсэргүүцэж, гэмт хэрэгт цохилт өгөх<sup>25</sup> юм гэжээ. Мөн тэрээр: “... хилийн гаднаас шашныг ашиглан бодлогоо нэвтрүүлэхийг хатуу эсэргүүцэж, шашны хэт үзлийн хөнөөлөөс урьдчилан сэргийлэх нь нэн чухал”<sup>26</sup> гээд цаашид шашны хууль бус үйл ажиллагаануудад хатуу ширүүн хандах хандлагаа нэмэгдүүлж байгаа тухайгаа мэдэгджээ. Тэрээр 2016 оны 4 сард Шашны хэргийн үндэсний зөвлөлийг даргалсан нь шашны асуудалд хандах анхаарлаа нэмэгдүүлснийг нь гэрчилнэ. Хятадын төрөөс хууль бус шашны эсрэг албан бус хамгийн хүчтэй зэвсэгээр “шинжлэх ухаан”-ыг өргөмжилж байна.

<sup>21</sup> 徐如雷:《开展神学思想建设,抵制邪教泛滥》社会问题研究丛书编辑委员会编《论邪教》,南宁:广西人民出版社,2001年,第42页。

<sup>22</sup> <http://www.chinafxj.cn/> “China Anti-Cult Network”

<sup>23</sup> [https://weibo.com/kaiwindblog?is\\_hot=1](https://weibo.com/kaiwindblog?is_hot=1)

<sup>24</sup> “Нэвчилт” гэдэг нь хилийн гаднах аливаа хүчин, бүлэг, байгууллага, хувь хүмүүсээс шашныг ашиглан бодлогоо нэвтрүүлэх, улмаар хятадын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчих, ухуулга сурталчилгаа явуулах, нийгэмд шашны хагарал бий болгох зэрэг асуудлыг зааж буй. Хятадад энэ асуудлыг “БНХАУ дахь гадаадын иргэний шашны үйл ажиллагааг хянан, зохицуулах тогтоол” ба бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулдаг байна.

<sup>25</sup> 习近平:《坚持依法治疆,团结稳疆,长期建疆,团结各族人民建设社会主义新疆》,《人民日报》,2014年5月30日第1版。-丁威:《习近平宗教工作思想视域下宗教治理政策探析》,《新疆社会科学》,2018年第1期,第71页。

<sup>26</sup> 习近平:《全面提高新形势下宗教工作水平》,《新华每日电讯》2016年4月24日第1版。

Культгийн талаарх хууль, эрх зүйн зарим зохицуулалт: Хятад улс Үндсэн хуулиндаа: “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн нь шашин шүтэх эрх чөлөөтэй. Ямар ч улсын байгууллага, нийгмийн бүлэг болон хувь хүн нь иргэний шашин шүтэх, эс шүтэхийг албадах, шашныг шүтдэг, эс шүтдэгээр нь ялгаварлан гадуурхаж болохгүй. Төрөөс хэвийн шашны үйл ажиллагааг хамгаална. Ямар ч хүн шашин шүтлэгийг ашиглан нийгмийн хэв журмыг эвдэх, иргэний бие эрүүл мэндэд хохирол учруулах, улсын боловсролын системийн үйл ажиллагаанд саад учруулж болохгүй. Шашны бүлгэм хийгээд шашны үйл ажиллагаа нь гадаад улсын эрхшээл, нөлөөнөөс ангид байна”<sup>27</sup> гэж заажээ. Харин культгийг зохицуулах асуудлыг төрөөс шашны талаар хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтаас “бодлогын хувьд” ангид авч үзэж байгаа нь тодорхой ажиглагдана.

1949 онд шинэ БНХАУ байгуулагдсанаас хойш хуулийн хүрээнд культэд хатуу хяналт тогтоож, тэмцэж иржээ. Тухайлбал, 1951 оны 2 сард “БНХАУ-ын хувьсгалын эсэргүүг шийтгэх тухай дүрэм” баталж, түүний 8 дугаар заалтад “нууц бүлгэмийг ашиглан хувьсгалын эсэргүү үйл ажиллагаа явуулагчийг цаазаар авах эсвэл хугацаагүйгээр хорих, хэрэг хөнгөн бол 3 жилээс дээш хугацаатайгаар хорино”<sup>28</sup> гэж заажээ. Үүнээс хойш 1954 (32 дугаар заалтад), 1957 (106 дугаар заалтад), 1963 (105 дугаар заалт), 1979 (99 дүгээр заалт) зэрэг онуудын Эрүүгийн хуульд “нууц бүлгэм, мухар сүсгийг ашиглан үйлдсэн хувьсгалын эсэргүү үйл ажиллагаа”-г хэрхэн шийтгэх тухай гэмт хэргийн заалтуудыг тогтоожээ. Мөн 1983 онд Үндэсний ардын төлөөлөгчдийн их хурлын байнгын хорооноос гаргасан “нийгмийн хэв журамд ноцтой хөнөөл учруулж буй гэмт хэрэгтнийг хатуу гэсгээх тухай тогтоол”, 1985 оны “Дээд шүүх, Улсын дээд дэсийн хянан байцаах хороо, Дотоодыг хамгаалах яам, Хууль зүйн яамнаас тэрслүү нууц бүлгэмийг шийдвэрлэж буй ажилд холбогдох асуудлуудын тухай мэдэгдэл”, 1986 оны 6 дугаар удаагийн Ардын төлөөлөгчдийн их хурлаас баталсан “БНХАУ-ын нийгмийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тухай шийтгэлийн дүрэм” зэрэг эрх зүйн актуудад нууц бүлгэм, мухар сүсгээс үүдэлтэй хууль бус үйл ажиллагаатай тэмцэх эрх зүйн орчныг сайжруулжээ.

1979 оны Эрүүгийн хуулийг 1997, 2015 онуудад шинэчлэн найруулж, нэлээд өөрчилж баталсан байна. Одоо үйлчилж байгаа 1997 оны Эрүүгийн хуульд культгийн тухай заахдаа (300 дугаар заалт): “нууц бүлгэм болон культгийг<sup>29</sup> зохион байгуулан эсвэл ашиглан, мөн мухар сүсгийг ашиглан улсын болон засаг захиргааны хууль, дүрмийг зөрчвөл (300:1) 3-аас 7 жил хүртэл хугацаатайгаар хорьж, мөнгөн торгууль ногдуулна; хэрэг онцгой хүнд бол 7 жилээс дээш хугацаатайгаар хорих эсвэл хугацаагүй хорих ялаар шийтгэж, мөн мөнгөн торгууль ногдуулах эсвэл эд хөрөнгийг хураана, хэрэг хөнгөн бол 3 жил хүртэлх хугацаатайгаар хориж, албадан хөдөлмөрлүүлж, чанга хяналтад байлгана, эсвэл улс төрийн эрхийг нь хасах эсвэл дан мөнгөн торгуул ногдуулна. Нууц бүлгэм болон культгийг зохион байгуулж эсвэл ашиглан, мөн мухар сүсгийг ашиглан бусдыг хуурч мэхлэх, эцэстээ хүний биеийг ноцтой гэмтгээх, цаашлаад үхүүлвэл 300-ийн 1 дүгээр зүйлээр шийтгэнэ. 300-ийн 1 дүгээр зүйлийг зөрчихийн зэрэгцээ нууц бүлэг болон культ, мухар сүсгийг ашиглан эсвэл зохион байгуулан эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, бусдын эд хөрөнгийг луйвардвал (300:2) “эрүүгийн хууль”-ийн 236 дугаар заалт<sup>30</sup> ба 266 дугаар заалтыг<sup>31</sup> тус тус үндэслэн шийтгэл оногдуулна”<sup>32</sup> гэжээ. Тус Эрүүгийн хуулийн уг заалтууд нь цаашид культээс үүдэлтэй хууль зөрчсөн аливаа хэргийг шийдвэрлэх хууль, эрх зүйн тусгай үндэслэл болж өгсөн байна.

Хятадын төрийн хууль тогтоох дээд шатны байгууллагуудаас Эрүүгийн хуулийн 300 дугаар заалтын хэрэгжилтийг хангаж, түүнийг задлан тайлбарласан дараахь хууль, эрх зүйн

<sup>27</sup> 中华人民共和国宪法》，北京：中国民主法制出版社，2018年。

<sup>28</sup> 刘正峰，周新国：《邪教的法律治理》，北京：社会科学文献出版社，2012年，第224页。

<sup>29</sup> 1979 оны Эрүүгийн хуульд тусгагдаагүй байсан “xie jiao” буюу культ гэдэг үгийг 1997 оны Эрүүгийн хуулинд шинээр нэмж оруулжээ.

<sup>30</sup> Хүчирхийлээс үүдэлтэй гэмт хэргийн тухай заалт.

<sup>31</sup> Луйвар(залилан)-ын гэмт хэргийн тухай заалт.

<sup>32</sup> [http://www.spp.gov.cn/spp/fl/201802/t20180206\\_364975.shtml](http://www.spp.gov.cn/spp/fl/201802/t20180206_364975.shtml)



баримт бичгүүдийг ар араас нь батлан мөрдүүлжээ. Үүнд, 1999 оны 10 сарын 30-нд БНХАУ-ын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны 12 дугаар хурлаар “культийн зохион байгуулалтыг хориглох, культийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай тогтоол”<sup>33</sup>-ыг батлан гаргасан байна. Тогтоолд, шашин болон хийн тамир зэрэг нэрийг ашиглан халхавчилж нийгмийн хэв журмыг ноцтой алдагдуулж буй культийн зохион байгуулалт ба шашны үйл ажиллагааг “хуулиар хориглон, эрс шийдэмгий яллан шийтгэнэ” гэжээ. Энэхүү шийдвэр нь “нийгмийн тогтвортой байдал, ард түмнийхээ ашиг тус, өөрчлөлт нээлттэй байдал, орчин үеийн социалист нийгмийн бүтээн байгуулалтын саадгүй амжилтын төлөө” юм гэжээ. Мөн уг тогтоолд, ард олны соёл боловсрол, шинжлэх ухааны мэдлэгийг дээшлүүлж, мэхлэгчийг мэхлэгдэгсэдээс ялган шийтгэж, нийгэм, нийтийн хүчийг культийн эсрэг уриалан зохион байгуулж, культийн асуудлыг цогц аргаар шийдэх тухай тусгасан байна.

Мөн Улсын дээд шүүх болон Улсын дээд дэсийн хянан байцаах хороо (Улсын прокурорын газар – О.Б) хамтран 1999 оны 10 сарын 30, мөн 2001 оны 6 сарын 4-ны өдөр “культийг зохион байгуулж эсвэл ашиглаж үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэхэд хуулийн хэрэглээний зарим асуудлын тухай тайлбар” (нэг)<sup>34</sup> болон “... тайлбар (хоёр)”<sup>35</sup>-ыг баталсан байна. Үүний дараа 2002 оны 5 сарын 20-нд Улсын дээд шүүх, Улсын дээд дэсийн хянан байцаах хороо хамтран “культийг зохион байгуулж эсвэл ашиглан үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэхэд хуулийн хэрэглээний зарим асуудлын тухай хариулт”<sup>36</sup> хэмээх баримт бичгийг нийтэлжээ. Эдгээр эрх зүйн баримт бичгүүдэд “культийн зохион байгуулалт” гэж чухам юуг авч үзэх тухай, мөн культийн зохион байгуулалттай гэмт хэрэг болон культээс үүдэлтэй гэмт хэрэг, гэмт хэргийн төрлүүдийг нарийн тодорхойлж, хэрэгтнийг эрүүгийн хийгээд бусад хуулийн ямар ямар зүйл, заалтаар хэрхэн яллан шийтгэх тухай тодорхой зааж өгчээ.

Тухайлбал, өмнө өгүүлсэн “... тайлбар (нэг)”-ийн 1 дүгээр зүйлд, “культийн зохион байгуулалт” гэдэг нь “шашин, хийн тамир эсвэл бусад нэрээр халхавчлан байгуулагдаж, удирдагчаа тахин шүтэж, мухар сүсэг, тэрс номлолыг зохиох, дэлгэрүүлэх зэрэг арга хэлбэрээр бусдыг мэхлэн төөрөгдүүлж, улмаар гишүүдээ өргөтгөн тэднийг хяналтандаа байлгаж, нийгэмд хор хөнөөл учруулж буй аливаа хууль бус зохион байгуулалтыг заана”<sup>37</sup> гэжээ. Мөн уг тайлбарт “нууц бүлгэм болон культийг зохион байгуулж, ашиглаж, эсвэл мухар сүсгийг ашиглаж” үндэсний аюулгүй байдалд аюул учруулсан<sup>38</sup>, улс үндэсний эв нэгдлийг үгүйсгэж, хагарал бий болгосон, нийгмийн хэв журмыг алдагдуулсан<sup>39</sup>, хувь хүн, олон нийтийн эрүүл мэндэд хохирол учруулсан<sup>40</sup>, улсын боловсролын тогтолцоог алдагдуулсан, иргэний эрх болон өмчийн эрхийг зөрчсөн зэрэг гэмт хэргүүдийг дотор нь нарийн ангилан ялгаж эрүүгийн болон бусад хуульд заасны дагуу шийтгэхээр заажээ. Энэ тайлбарууд нь культийн зохион байгуулалттай үйлдсэн болон культээс үүдэлтэй хууль бус үйл ажиллагааг хэрхэн зохицуулах тухай хуулийн гол хэрэглэгдэхүүн мөн бөгөөд бусад хууль, дүрмүүдтэй хослон хэрэгжиж байна.

<sup>33</sup> 《全国人民代表大会常务委员会关于取缔邪教组织，防范和惩治邪教活动的决定》，1999年10月30日。

<sup>34</sup> 《最高人民法院，最高人民检察院关于办理组织和利用邪教组织犯罪案件具体应用法律若干问题的解释》第1条。

<sup>35</sup> 《最高人民法院，最高人民检察院关于办理组织和利用邪教组织犯罪案件具体应用法律若干问题的解释》第2条。

<sup>36</sup> 《最高人民法院，最高人民检察院关于办理组织和利用邪教组织犯罪案件具体应用法律若干问题的解释》，2002年。

<sup>37</sup> 《最高人民法院，最高人民检察院关于办理组织和利用邪教组织犯罪案件具体应用法律若干问题的解释》第1条。

<sup>38</sup> Хил дамнасан хулгай, хууль бус худалдаа явуулах, төрийн нууцтай холбоотой мэдээлэл, бичиг баримт, эх сурвалж материалыг хууль бус аргаар олж авах, тагнах, турших, мэдээллийг хилийн чанадад гаргах, засгийн газар, засаг захиргаа, төрийн байгууллагад халдах, заналхийлэх, төрийн албан хаагчидыг хуулийн дагуу ажил үүргээ биелүүлэхэд нь саад учруулах, айлган сүрдүүлэх, дарангуйлах зэрэг үйл ажиллагаа явуулах, үйлдвэр аж ахуйн нэгжид хохирол учруулсан гэх мэт.

<sup>39</sup> Күлтийн шинж чанартай жагсаал, цуглаан явуулсан, гишүүд болон бусад хүмүүсийг цуглуулж зохион байгуулалттайгаар газар газарт хэрэн хэсэх, күлтийн хуульгүйн чанартай зүйлс(сонин, сэтгүүл, зураг, уриа лоозон, CD, DVD, VCD гэх мэт)-ийг олон нийтэд тараах, нэвтрүүлсэн гэх мэт ангилан заажээ.

<sup>40</sup> Хүний амийг хохироосон, хохироолгосон, охид эмэгтэйчүүдийг хүчирхийлсэн, бусдыг амиа хорлох, өөрийгөө зэрэмдэглэх, өөрийгөө шатаах, дэлбэлэх зэрэгт туслах, түүнийг өдөөх, турхирах, зохион байгуулах, төлөвлөх зэрэг бусад аюултай арга хэрэгслээр олон нийтийн аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулах зэрэг хэргүүдийн тухай нарийн ангилан заажээ.

Кульг хийгээд культуийн зохион байгуулалттай үйл ажиллагааг дараахь хууль, дүрмүүдээр хязгаарлаж, мөн зохицуулж байна. Үүнд, “Хилийн гаднах засгийн газрын бус аливаа зохион байгуулалтын хилийн доторх үйл ажиллагааны зохицуулалтын тухай хууль”, “Хурал, чуулган, сүрт жагсаал хийх тухай хууль”, “Шуудангийн тухай хууль”, “Терроризмын тухай хууль”, “Цахилгаан холбооны тухай хууль”, “Телевизийн удирдлага, зохицуулалтын тухай дүрэм”, “Шашны хэрэг эрхлэх дүрэм”, “Хэвлэл мэдээллийн хяналт, зохицуулалтын тухай дүрэм”, “Нийгмийн бүлгүүдийн бүртгэл удирдлагын тухай дүрэм”, “Цахим сүлжээн дэх интернет худалдаа үйлчилгээний талбар (платформ)-ын зохицуулалтын тухай дүрэм”, “Цахим сүлжээний хяналт, зохицуулалтын тухай дүрэм”, “Бизнесийн шинж чанартай үзвэр үйлчилгээний зохицуулалтын тухай дүрэм”, “Улсын хэв журмын зохицуулалтын тухай дүрэм”, “Компьютер, мэдээллийн сүлжээн дэх олон улсын сүлжээний аюулгүй байдлын удирдлагын тухай журам” зэрэг бусад хууль, дүрмүүд багтана. Жишээ нь, “Хэвлэл мэдээллийн хяналт, зохицуулалтын тухай дүрэм”-ийн 25 дугаар заалтад “аливаа хэвлэн нийтлэгдэж байгаа зүйл нь культу, мухар сүсгийг сурталчилсан агуулгатай байж үл болно”<sup>41</sup>, “Цахим сүлжээний хяналт, зохицуулалтын тухай дүрэм”-ийн 15 дугаар зүйлд, улсын шашны бодлогын эсрэг культу болон мухар сүсгийг сурталчилсан агуулгатай мэдээллийг цахим сүлжээнд хувиран олшруулах, нийтлэх, түгээхийг хориглох тухай заасан байна.<sup>42</sup> Хэрвээ шуудан холбоо, хэвлэл мэдээлэл, телевиз, үзвэр үйлчилгээ, цахим орчинд олон янзын хэлбэрээр культуийг сурталчилвал “Улсын хэв журмын хяналт, удирдлагын тухай дүрэм”, “Компьютер, мэдээллийн сүлжээн дэх олон улсын сүлжээний аюулгүй байдлын хяналт, удирдлагын тухай дүрэм” зэрэг холбогдох хууль, дүрэмд үндэслэн, тухайн нэгжийг цахим орчинд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг цуцлах, сүлжээг хаах, вэб сайтыг түр хаах, бизнесийн үйл ажиллагааг нь түр зогсоох хүртэл арга хэмжээ авахаар заасан байна. Эдүгээ хятадын хуульч, судлаачдаас культуийн эсрэг тэмцэж буй одоогийн хууль эрх зүйн орчныг цаашид илүү сайн боловсруулж, улмаар аль болох богино хугацаанд культуийг зохицуулсан “цогц шинжтэй, тусгай хууль” тогтоох тухай саналыг идэвхитэй дэвшүүлж байна.

Эцэст нь хэлэхэд, хятад дахь культуийн асуудал нь америк зэрэг улсуудын хувьд хятад дахь шашны эрх чөлөөний асуудлыг хөндсөн эмзэг сэдэв мөн боловч, хятадын төрөөс культутэй шинэ хятад улс байгуулагдсанаас нааш эрс тэмцсээр иржээ. Тус улсад культуийн асуудлыг шашны эрх чөлөө гэдгээр бус, харин төрийн бодлого, зохицуулалтын үүднээс хөндөж, культуийн үнэн төрх, нийгэм дэх хор хөнөөлийг бодитой тодорхойлж, культуээс үүдэлтэй хууль зөрчсөн үйл ажиллагааг хууль, эрх зүйн нижгээд баримт бичгийн хүрээнд зохицуулж байна. Культуийн тухай хуулийн зохицуулалтын агуулгыг ажиглавал, төр культуийн улс төрийн зорилгоос ихээхэн сэрэмжилж буй нь мэдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, төрөөс культуийг хориглох нь нэг талаар тэрс номлол, мухар сүсгийг, нөгөө талаар төрийн эрхэнд санаархагсад цохилт өгч буй ажил болж байна. Энэ бол өнөөгийн хятад улсаас культуийн талаар хэрэгжүүлж буй бодлогын гол онцлог гэлтэй юм. Эдүгээ хятадын төрөөс культуийн талаар хэрэгжүүлж буй бодлого нь культуээс урьдчилан сэргийлэх, культуийг хязгаарлах, хориглох, шийтгэх гэсэн үндсэн үйл ажиллагаанд төвлөрч байна гэж үзэж байгаа болно.

## ABSTRACT

In the Constitution of China, it is stated that “normal religious operation will be supported”. It is the concept of accepting registered religion and rejecting the ones who is not registered to the government. The religion that is not included in the normal ones called Xie Jiao, which is translated into cult or evil cult in English. There are no regulations and laws that governs cult in China. But

<sup>41</sup> <http://www.gapp.gov.cn/sappjft/govpublic/6681/356061.shtml>

<sup>42</sup> 《互联网上服务营业场所管理条例及其配套规定》，北京：法律及其配套规定丛书，中国法制出版社，2018年第236页。



it is regulated by crime and other certain laws. Main policy from the Chinese government focuses on the operation of prevention, control and injunction, punishment.

### НОМ ЗҮЙ

1. 《全国人民代表大会常务委员会关于取缔邪教组织，防范和惩治邪教活动的决定》，1999年10月30日。
2. 《最高人民法院，最高人民检察院关于办理组织和利用邪教组织犯罪案件具体应用法律若干问题的解释》第1条。
3. 《最高人民法院，最高人民检察院关于办理组织和利用邪教组织犯罪案件具体应用法律若干问题的解释》第2条。
4. 《最高人民法院，最高人民检察院关于办理组织和利用邪教组织犯罪案件具体应用法律若干问题的解释》，2002年。
5. 刁五一：《当代中国邪教性质及其社会根源 – 兼论建立“邪教现象预警系统”》，社会问题研究丛书编辑委员会编《论邪教》，南宁：广西人民出版社，2001年。
6. 颜邦华：《宗教立法法诺干问题的探讨》，湖北：《湖北社会科学》2001年第1期。
7. 李秀请：《呼喊派的反动本质及危害》，《河南公安高等专科学校学报》，1992年第2期。
8. 蔡少卿，孔样涛：《试论当代邪教的九个特点》，江苏：江苏社会科学，1997年第6期。
9. 李昭主编：《邪教·会道门·黑社会 – 中外民间秘密结社纵横谈》，群众出版社2000年版页。
10. 徐如雷：《开展神学思想建设，抵制邪教泛滥》载社会问题研究丛书编辑委员会编《论邪教》，南宁：广西人民出版社，2001年。
11. 吴东升：《邪教的密码》，北京：社会科学文献出版社，2005年。
12. 牟家骥：《我国新时期邪教问题研究》，山东：《山东警察学院学报》，2006年第3期。
13. 陆中俊主编：《我国对当代邪教组织犯罪问题的对策与治理》，北京：中国人民公安大学出版社，2005年。
14. 刘正峰，周新国：《邪教的法律治理》，北京：社会科学文献出版社，2012年，第1页。
15. 冯玉军：《邪教的法律性质及其治理创新》，北京：北京联合大学学报(人文社会科学版)，2014年第6期。
16. 习近平：《坚持依法治疆，团结稳疆，长期建疆，团结各族人民建设社会主义新疆》，《人民日报》，2014年5月30日第1版。
17. 习近平：《全面提高新形势下宗教工作水平》，《新华每日电讯》2016年4月24日第1版。
18. 内蒙古自治区教育厅学校安全管理处：《学校防范邪教》，呼市：呼和浩特市苏虎街实验小学印刷厂，2016年。
19. 陈运雄：《中美治理邪教的法律与政策比较》，湖南：湖南农业大学出版社，2016年第12期。
20. 《中华人民共和国宪法》，北京：中国民主法制出版社，2018年。
21. 丁威：《习近平宗教工作思想视域下宗教治理政策探析》，《新疆社会科学》，2018年第1期。
22. 《互联网上服务营业场所管理条例及其配套规定》，北京：法律及其配套规定丛书，中国法制出版社。
1. [http://www.spp.gov.cn/spp/fl/201802/t20180206\\_364975.shtml](http://www.spp.gov.cn/spp/fl/201802/t20180206_364975.shtml)
2. <http://www.gapp.gov.cn/sapp/rft/govpublic/6681/356061.shtm>
3. <http://xwjz.eastday.com/epublish/gb/paper140/18/class014000004/hwz297143.htm>
4. <http://news.qq.com/a/20140603/006824.htm>
5. <http://society.people.com.cn/n/2014/0603/c1008-25098722.html>
6. <http://www.chinafxj.cn/>
7. [https://weibo.com/kaiwindblog?is\\_hot=1](https://weibo.com/kaiwindblog?is_hot=1)